# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 30 өдөр Дугаар А/394 Улаанбаатар хот

## Нийслэлийн нийтийн тээврийн газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,975,000.00 (гурван сая есөн зуун далан таван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн нийтийн тээврийн газар (Д.Отгонжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ<br>ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/394 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн нийтийн тээврийн газар

| № | Эд хөрөнгийн нэр | Ашиглалт-ад орсон он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр / | | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгж үнэ | нийт үнэ | |
| тоног төхөөрөмж | | | | | | | | |
| 1 | Компьютерийн дэлгэц | 2024 | сайн | ш | 1 | 540,000.00 | 540,000.00 | Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар |
| 2 | Компьютер dell optiplex 7010 | 2024 | сайн | ш | 1 | 3,435,000.00 | 3,435,000.00 | |
| **Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн** | | | | | **2** | | **3,975,000.00** | |